**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН**
**ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2016 оны 11 сарын 30 өдөр Дугаар 133 Номгон

Балансаас балансад хөрөнгө
шилжүүлэх тухай

Зэвсэгт хүчний 339 дүгээр ангид срон нутгаас 150 гаруй офицер, ахлагч, 60 гаруй энгийн ажилчин албан хаагч ажиллаж байгаа бөгөөд цаашид мэргэжилтэй болон мэргэжилгүй ажилчдыг байнгын ажлын байраар хангах нөхцөл бололцоог бүрдүүлэн ажиллах, мөн шилжүүлэн авах мужааны байрыг зэвсэг, галт хэрэгслийн агуулахын зориулалтаар, улаан булангийн барилгыг байлдааны техникийн гражийн зориулалтаар, аж ахуйн складны барилгыг хичээл сургалтын байрны зориулалтаар, уурын зуухыг зориулалтын дагуу ашиглахаар ирүүлсэн саналыг хэлэлцээд

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 3 дахь заалт, Батлан хамгаалах тухай хуулийн 17.1.8 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит төсвийн байгууллага болон төсөвт үйлдвэрийн газар эд хөрөнгө олж авах, бүртгэх, дуудлагаар худалдах, шилжүүлэх, актлах журам”-ын 1.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Аймгийн Орон нутгийн өмчийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 5 нэрийн 337741700 төгрөгийн хөрөнгийг Зэвсэгт хүчний 339 дүгээр ангид, Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2 нэрийн 9480000 төгрөгийн хөрөнгийг Цэвэр хот ХХК-д тус тус нэгдүгээр хавсралтад заагдсаны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Шилжүүлсэн хөрөнгийг комисс томилон хүлээлгэн өгч, хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих журмын дагуу хийхийг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ч.Мөнхцэцэг/-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА Ц.ОТГОНБАЯР

16167

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2016 оны 11 дүгээр сарын
30-ны өдрийн 133 дугаар тогтоолын хавсралт

## БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| № | Аймаг /сум/-ын нэр | Байгууллагын нэр | Эд хөрөнгийн нэр | Ашиглалтанд орсон огноо | тоо | НБҮ | Бүгд үнэ | Элэгдэл | Үлдэгдэл өртөг | Шилжүүлэн авсан байгууллагын нэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Баянхонгор аймаг | ОНӨГазар | Уурын зуухны барилга | 2009.01.01 | 1 | 8,107,200 | 8,107,200.00 | 8,107,200.00 | - | ЗХ-ны 339-р анги |
| 2 | Баянхонгор аймаг | ОНӨГазар | Улаанбулан | 2012.01.01 | 1 | 252,861,700 | 252,861,700.00 | 31908738.51 | 220,952,961.49 | ЗХ-ны 339-р анги |
| 3 | Баянхонгор аймаг | ОНӨГазар | Аж ахуйн склад | 2012.01.01 | 1 | 2,505,700 | 2,505,700.00 | 307412.19 | 2,198,287.81 | ЗХ-ны 339-р анги |
| 4 | Баянхонгор аймаг | ОНӨГазар | Дезилийн байр-мужааны цех | 2012.01.01 | 1 | 68,335,900 | 68,335,900.00 | 8383802.35 | 59,952,097.65 | ЗХ-ны 339-р анги |
| 5 | Баянхонгор аймаг | ОНӨГазар | Уурын зуух 2 тогоотой | 2012.01.01 | 1 | 5,931,200 | 5,931,200.00 | 727670.39 | 5,203,529.61 | ЗХ-ны 339-р анги |
| | | | | | | | 337,741,700.00 | 49,434,823.44 | 288,306,876.56 | |
| 1 | Баянхонгор сум | Сумын ЗДТГ | Портер | 2014.01.05 | 1 | 8280000 | 8,280,000.00 | 1045000.11 | 7,234,999.89 | Цэвэр хот ХХК-д |
| 2 | Баянхонгор сум | Сумын ЗДТГ | Нохой устгалын буу | 2016.01.08 | 1 | 1200000 | 1,200,000.00 | 150000 | 1,050,000.00 | Цэвэр хот ХХК-д |
| | | | | | | | 9,480,000.00 | 1,195,000.11 | 8,284,999.89 | |
| | | | | | | | 347,221,700.00 | 50,629,823.55 | 296,591,876.45 | |

____________oOo____________